

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН 2026 ОНЫ 2-Р ДУГААР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2026 оны 05 дугаар сарын 29

Улаанбаатар хот


“Монголын төмөр зам” ТӨХК-ийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжиж байгаа бөгөөд цаашид анхаарах асуудлыг тодорхойлон, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор энэхүү өргөдөл гомдлын тайлан мэдээллийг танилцуулж байна.

1. Өргөдөл, гомдлыг хүлээн авах хэлбэр:

- ✓ Ажилтан албан хаагчдаас цаасан хэлбэр, цахим шуудангаар;
- ✓ Иргэн, хуулийн этгээдээс Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем болон, цаасаар;
- ✓ Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс гэх мэт хэлбэрээр өргөдөл гомдлын хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.

2. Хүлээн авсан өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд буюу 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөрт “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ажилтан албан хаагчдаас нийт 211, Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр 4 өргөдөл, хуулийн этгээдээс албан бичгээр нийт 3 өргөдөл гомдол хүлээн авч холбогдох ажилтнуудад шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Графикаар үзүүлбэл:



3. Өргөдөл гомдол шийдвэрлэлт:

№	Өргөдөл, гомдол	Нийт ирсэн	Хугацаандаа шийдвэрлэсэн	Судлагдаж байгаа	Хугацаа хэтэрсэн
1	Хуулийн этгээд, иргэд албан бичгээр	3	-	3	-
33	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр	4	4	-	-
4	Ажилтан албан хаагч	211	178	33	-



4. Өргөдөл, гомдлын дүн шинжилгээ:

Компанид ирсэн өргөдөл гомдлыг хянаж үзэхэд ажилтан албан хаагчдын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны тухай өргөдөл, гомдол буюу чөлөө хүсэх, шилжин ажиллах хүсэлтүүд зонхилох хувийг эзэлж байна.

Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв болон албан бичгээр ирсэн өргөдөл гомдол нь Багахангай-Хөшигтийн хөндий чиглэлийн төсөлтэй холбоотой өргөдөл, гомдол байсан бөгөөд холбогдох газар хэлтэст хугацаа алдахгүй шилжүүлж шийдвэрлэлтэд хариу өгсөн.

Цаашид ажилтан албан хаагчид болон иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шалгаж, шийдвэрлэх арга хэмжээ авах, дүн шинжилгээ сэтгэл ханамжийг дээшлүүлэх талаар анхааран ажиллаж байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ДАРГА

Д.СЭРЭЭДОРЖ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Г.АРИУНТУЯА